



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 528

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2, 6.3.4, 6.4.3, 6.4.4, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 19,900,000.00 (арван есөн сая есөн зуун мянган) төгрөгийн балансын үнэ, 14,206,388.61 (арван дөрвөн сая хоёр зуун зургаан мянга гурван зуун наян найман төгрөг жаран нэгэн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, “Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал В.Адъяа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Компанийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс хасуулсан тодорхойлолт, арга хэмжээний биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан тайлагнах.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.Дуланж

Д.НАРАНГЭРЭЛ

132001491

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн
дугаар тогтоолын хавсралт

**"ЭРДЭНЭТ-БУЛГАНЫ ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ
БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон огноо	Балансын үнэ,	Хуриятлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
			(төгрөг)		
1	Ниссан Экстрайл, 22-26 OPX, NT30205443	2006/2014	19,900,000.00	14,206,388.61	5,693,611.39
	Нийт дүн		19,900,000.00	14,206,388.61	5,693,611.39
			(арван есөн сая есөн зуун мянган)	(арван дөрвөн сая хоёр зуун зургаан мянга гурван зуун наян найман төгрөг жаран нэгэн мөнгө)	(таван сая зургаан зуун ерэн гурван мянга зургаан зуун арван нэгэн төгрөг гучин есөн мөнгө)